

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР**

2019 оны 01 дүгээр сарын 02

№

Өлгий сум

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН
2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

“Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь хэсэг, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/133 тушаалыг тус тус үндэслэн Цагдаагийн газрын 2018 оны үйл ажиллагааны тайланг бэлтгэж, Иргэний зөвлөл, оршин суугчдад тайлагнаж байна. Үүнд:

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

1.1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/01 дүгээр тушаалаар баталсан “Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлж, ил тод, шударга, шуурхай, хуульч ажиллагааг хэвшүүлнэ” зорилт түүний шалгуур үзүүлэлтийг 90.6, Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан нийт 48 төрлийн ажил, арга хэмжээний хэрэгжилтийг 91.4 хувьтай тус тус хангаж ажиллалаа.

Зорилт, төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласны үр дүнд цагдаагийн газрын удирдлага, зохион байгуулалт, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилт, төсөв санхүүгийн үйл ажиллагаа сайжирч, алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, сахилга хариуцлага, манлайлал дээшилсэн болох нь тоо баримтуудаар харагдаж байна.

1.2. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/58 дугаар тушаалаар тус Цагдаагийн газарт “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсэг”-ийг 3, 2018 оны А/212 дугаар тушаалаар “Шуурхай удирдлагын тасаг”-ийг 12 орон тоотой тус тус байгуулсан нь ажил үүргийн хувьд үүсч буй ажлын ачааллыг тэнцвэржүүлэх бүтцийн өөрчлөлт болсон.

1.3. Тус Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасаг 2018 онд ажлын үр дүнгээр Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2-р байранд эрэмбэлэгдсэн.

1.4. Цагдаагийн газрын 2017 оны үйл ажиллагааны тайланг 13 сум, 1 тосгоны оршин суугчдад, 2018 оны 1, 2, 3 дугаар улирлын үйл ажиллагааны тайланг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим орчинд тус тус тайлагнаж, цагдаагийн газрын ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллалаа.

1.5. Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, гаргасан ололт амжилт, тэргүүн туршлагыг иргэд, олон нийтэд сурталчлах, цагдаагийн газрын түүхийг бичих, бататгах зорилгоор “ӨЛГИЙ-ЦАГДАА” сэтгүүлийг 5 дахь жилдээ гаргаж, иргэд, олон нийтэд үнэ төлбөргүй хүргүүлэн үйл ажиллагааг сурталчлав.

1.6. Тус Цагдаагийн газарт ажиллаж байгаад өндөр настан болон цэргийн алба хаасны тэтгэвэрт гарсан нийт 71 ахмад ажилтанд “Сар шинэ”, “Наурыз”-ын

баяр, “Ахмадын эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.

Тухайлбал: “Ахмадын эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан Цагдаагийн газрын 2018 оны ажлын товч тайланг танилцуулах, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, зарим ахмадуудад ЦЕГ болон дотоодын цэргийн шагнал гардуулах, сувилалд хамруулах, санал хүсэлтийг нь сонсох, хүндэтгэлийн зоог барих зэрэг ажил, арга хэмжээг хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан.

1.7. Дотоод нөөц бололцоонд тулгуурлан Цагдаагийн газрын хашаанд цайны газар, эд зүйл хадгалах зоорь, албаны нохойн байрыг зориулалтын дагуу барьж ашиглаж байна.

Цагдаагийн газрын хашаанд 5 ханатай эсгий гэрийг тохижуулж, алба хаагчдын амрах, хооллох нөхцөл боломжоор хангав.

Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил:

Гэмт хэрэгтэй тэмцэх ажлын чиглэлээр:

2.1. Тус Цагдаагийн газар 2018 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн талаарх 2572 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан.

Нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 481 нь гэмт хэргийн шинжтэй, 2131 нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байсан бол гэмт хэргийн шинжтэй 481 гомдол мэдээллийн 449 буюу 93.3 хувийг 5 хоногт, 28 гомдол, мэдээлэл буюу 5,8 хувийг 6-аас дээш хоногт шийдвэрлэж, Цагдаагийн ерөнхий газраас тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангасан.

Мөн зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1628 буюу 76,3 хувийг 3 хоногт, 497 буюу 23.3 хувийг 4 дээш хоногт тус тус шуурхай шалгаж шийдвэрлэсэн.

2.2. Аймгийн хэмжээнд 318 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 1 хэргээр буюу 0.3 хувиар буурсан.

2.3. Тайлангийн хугацаанд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 274 хэрэг бүртгэгдснээс 172 хэрэг буюу 62.8 хувийг илрүүлсэн.

Тодорхой төрлийн гэмт хэргүүдийг авч үзвэл:

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 62 хэргээр буюу 56.8 хувиар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 6 хэргээр буюу 50 хувиар, алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг 8 хэргээр буюу 57.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 4 хэргээр буюу 28.5 хувиар, хулгайлах төрлийн гэмт хэрэг 15 хэргээр буюу 22.3 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 6 хэргээр буюу 35.2 хувиар, хөрөнгө завших гэмт хэрэг 7 хэргээр буюу 58.8 хувиар тус тус өссөн нь гэмт хэргийн илрүүлэлт ахисан, мөн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилттэй холбоотой.

2.4. Гэмт хэргийн улмаас иргэд аж ахуй нэгжид 532.6 сая төгрөгний хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 289.6 сая төгрөгийн хохирлыг буюу нийт учирсан хохирлын 61.7 хувийг нөхөн төлүүлж, 135.6 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын учирсан хохирлыг

барагдуулах, нуугдмал өмч, хөрөнгийг илрүүлэх, хөрөнгө битүүмжлэх, хамгаалах үйл ажиллагааны үр дүн дээшиллээ.

2.5. Нийт 10760 зөрчил илрүүлсэн нь өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 2515 зөрчил буюу 23.3 хувиар өссөн нь гэмт хэргийг зөрчлийн шатан илрүүлэх ажилд ахиц гарсныг харуулж байна.

2.6. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд нисдэг камерыг ашиглаж байна.

Нийтийн хэв жрам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, замын цагдаагийн үйл ажиллагааны чиглэлээр:

2.7. Үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн криминалоги судалгаа, цахим зураглалд үндэслэн Цагдаагийн газрын даргын 2018 оны А/10, А/21 тоот тушаалаар эргүүлийн нэгдсэн байршилтийг тус тус шинэчилэн батлуулж, гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг, хүн амын суурьшил, хөдөлгөөн ихтэй газруудад хяналт тавин ажилласан.

Эргүүлийг өдөр болон оройн цагийн хуваариар, баяр, наадам, тэмдэглэлт өдөр, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэглэлд шилжин ажиллаж байгаа үед 24 цагийн хугацаанд тодорхой цагийн хуваариар томилон ажиллуулсан.

2.8. Нийтийн хэв журам хамгаалах, замын цагдаагийн чиглэлээр давхардсан тоогоор 4086 алба хаагч 1968 цагийн хугацаанд эргүүлийн үүрэн гүйцэтгэж, эргүүлийн хяналтаар нийт 10760 тооны зөрчил илрүүлэн үр дүнтэй ажилласан.

Үүнээс: Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 412 жолоочийг илрүүлж, 304 жолоочийн эрхийг 1 жилээр хасч, 108 жолоочийг шүүхийн шийдвэрээр 7-30 хоногийн хугацаатай баривчлах шийтгэл оногдуулсан.

Камерын тусламжтайгаар нийт 1803 хэрэг, зөрчил илрүүлж, зөрчил үйлдэгч нарт 34.260.000 төгрөгний торгуулийн шийтгэл оногдуулав.

2.9. Ардын хувьсгалын 97 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үеэр цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүн өндөржүүлсэн бэлэн байдалд ажилласан ба гэмт хэрэг бүртгэгдээгүй.

2.10. Аймгийн нутаг дэвсгэрт 2018 оны 07 дугаар сарын 14-ны өдрөөс хойш үргэлжлэн орсон борооны улмаас аймгийн төв Өлгий сумын 2, 3, 12, 13 дугаар багийн олон айл, өрхийн хашаа, байшин үерийн усанд нуран унаж, аймгийн хэмжээнд гамшгийн бэлэн байдалд шилжиж ажилласан.

Үерийн гамшгийн хугацаанд давхардсан тоогоор 222 алба хаагч, 45 цагийн хугацаанд иргэдийн аюулгүй байдлыг хангах, авран хамгаалах, нүүлгэн шилжүүлэх, нийтийн хэв журам сахиулах үүргээ хангалттай хэмжээнд гүйцэтгэн ажилласнаар үерийн үед хүний амь нас эрсэдсэн, иргэд, байгууллагын эд хөрөнгө хулгайлагдсан зэрэг аливаа гэмт хэрэг, зөрчил үйлдэгдээгүй.

2.11. Тус аймгийн Алтанцөгц, Сагсай, Дэлүүн, Цэнгэл сумдын нийт 7 багт зохион байгуулагдсан нөхөн болон дахин сонгууль, Булган, Улаанхус, Дэлүүн, Ногооннуур, Баяннуур, Толбо сумдын ойн баяр наадмын хамгаалалтыг зохион байгуулсан бөгөөд гэмт хэрэг, зөрчилгүй бүртгэгдээгүй.

2.12. Тус аймагт зохион байгуулагдсан урлаг, соёлын болон бусад арга хэмжээний 15, жагсаал, цуглааны 2 удаагийн хамгаалалтыг төлөвлөгөө, зураглалын дагуу зохион байгуулсан.

2.13. Улсын онц чухал объектын хамгаалалтад Дотоодын цэргийн тусгай салааны 3 харуулын дарга, 12 ахлагч нийт давхардсан тоогоор 7560 цагийн үүрэг гүйцэтгэж, объектод байнгын үнэмлэхээр нэвтэрсэн иргэн 88, тээврийн хэрэгсэл 98, гадаад иргэн 1, гаднаас нэвтэрсэн 204 иргэнийг зохих журмын дагуу шалган нэвтрүүлэн, нийт 26.244 удаагийн хөдөлгөөнд хяналт тавьж ажиллалаа.

Дотоодын цэргийн командлагчийн 2018 оны А/01 дүгээр тушаалаар баталсан “Улсын онц чухал объектыг хамгаалах үйл ажиллагааны стандарт”-ыг алба-ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилгоор 13,217,800 /арван гурван сая хоёр зуун арван долоон мянга найман зуу/ төгрөгний бараа материалын хөрөнгө оруулалт хийгдлээ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

2.14. Цагдаагийн газраас нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд уялдуулан нийт 30 удаа хэсэгчилсэн арга хэмжээ, 6 удаагийн нэгдсэн үзлэг шалгалт, 32 удаа сургалт, мэдээлэл, сурталчилгаа, 60 удаа уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага, 6 удаа өдөрлөг, 5 удаа уралдаан, тэмцээнийг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой зохион байгуулсан бөгөөд нийт 13249 хүн хамрагдав.

Тухайлбал: “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, “Хулгайлах гэмт хэргийг бууруулах арга зам ...”, “Гэр бүлийн орчин ба хүүхдийн хүмүүжил”, “Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлэг,

“Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх нь”, “Бид ирээдүйн манлайлагчид”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, инноваци нэвтрүүлэх нь”, “Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд орон нутгийн иргэдийн оролцоо”, “Залуучууд ба шинэ төрлийн гэмт хэрэг”, “Хил дамнасан мал хулгайлах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудал, шийдэл”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө хамтдаа” сэдэвт сургалт, зөвлөгөөн,

“Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, “Гэр бүл, нийгмийн орчинд хүүхдийн эрхийг хангахад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал,

“Бяцхан цагдаа”, “Замын хөдөлгөөний цагаан толгой” сэдэвт уралдаан тэмцээн болон “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг 6 удаа тус тус зохион байгуулсан.

2.15. Гэмт хэргийн нөхцөл байдал болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх талаар аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг даргад 42 санал бүхий 15 танилцуулгыг хүргүүлж, саналын 58 хувийг шийдвэрлүүлсэн.

2.16. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн тогтоол-3, аймгийн Засаг даргын захирамж-5, хөтөлбөр-1, журам-1 нийт 10 шийдвэр гаргуулан хэрэгжилтийг хангуулан ажилласнаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил иргэд, олон нийтийн оролцоо хангагдсан.

2.17. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ түүний үр дүнгийн талаар: телевизээр 67 удаагийн, радиогоор 33 удаагийн, “Баян-Өлгий Цагдаагийн газар” фейсбүүк болон www.bayan-ulqii.police.gov.mn цахим хуудсанд 159 удаагийн мэдээ, мэдээлэл байршуулж, нэвтрүүлэг, ярилцлага бэлтгэн хүргэсэн.

2.18. Нийт 50 төрлийн 11196 ширхэг гарын авлага, зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмжийг иргэд, олон нийтэд тараав.

2.19. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа 34 төрийн болон аж ахуйн нэгжтэй “Хамтран ажиллах гэрээ”-г 1 жилийн хугацаатай байгуулан хэрэгжилтийг хангасан нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд үр дүнгээ өгсөн.

Тухайлбал: Гэрээ байгуулсан 34 байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан орон тооны бус ажилтныг томилсон, үйл ажиллагаа явуулж байгаа орчиндоо хяналтын камер суурилуулсан, авто зогсоол, хууль сурталчлах самбар, танхимтай болсон гэх мэт олон ажил хийгдсэн.

Цагдаагийн байгууллагаас хүргүүлсэн албан шаардлагын дагуу аймгийн төрийн болон аж, ахуйн нэгж, байгууллагууд нийт 700 гаруй ширхэг хяналтын камерийг тус тусын байгууллагадаа байрлуулсан бөгөөд үүнийг цагдаагийн газраас “Google earth” цахим программд байршуулж гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд ашиглаж байгаа ба төрийн болон төрийн бус байгууллага төвлөрсөн Өлгий сумын 5 дугаар багийг камерийн хяналтын бүс болгосон.

Гурав: Цагдаагийн алба хаагчийн сургалт, сахилга, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээлэл:

1.2. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/01 дугаар тушаалаар баталсан “Албаны сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр, төлөвлөгөө”, 2018 оны А/08 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2018 онд явуулах сургалтын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн хангуулах зорилгоор Цагдаагийн газрын даргын 2018 оны А/06 дугаар тушаалаар “Албаны сургалт явуулах баг байгуулж, сургалтын төлөвлөгөө, хуваарь”-ийг баталж, хэрэгжилтийг хангуулав.

1.3. Удирдах ажилтны 4 удаагийн сургалтад 4, давтан 6 удаагийн сургалтад 19, мэргэшүүлэх 13 удаагийн сургалтад 22, ур чадварын 2 удаагийн сургалтад 6, дадлагын 6 удаагийн сургалтад 165, давхардсан тоогоор албаны 61 удаагийн сургалтад 5087 алба хаагчийг хамруулснаар алба хаагчдын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, харилцааны соёл, албаны бэлэн байдал, цэрэгжилч, жагсаалч байдал, сахилга хариуцлага дээшилсэн эерэг өөрчлөлтүүд гарсан.

1.4. Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, шалтгаан нөхцөлийг тогтоож, арилгуулах, зөрчил дутагдлыг давтан гаргуулахгүй байх, урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүний сахилгын зөвлөгөөнийг 4 удаа зохион байгуулсан, давхардсан тоогоор 896 алба хаагчаас баталгаа гаргуулан авч, хэрэгжилтийг хангуулсан, Цагдаагийн газрын даргын 2018 оны А/55 дугаар тушаалаар 6 хүний бүрэлдэхүүнтэй “Сахилга, ёс зүйн хороо”-г байгуулсан, цагдаагийн газрын тасаг, хэсгийн дарга, ёс журмын эргүүлүүд

алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласнаар алба хаагчдын сахилга, хариуцлага дээшлэхэд нөлөөлсөн.

Сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний үр дүнд сахилгын зөрчил гаргасан алба хаагчийн тоо 16 алба хаагч буюу 52.9 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан.

Дөрөв: Алба хаагчдын нийгмийн асуудал, үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар:

1. Алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор энгэрийн камер, автомат хаалганы төхөөрөмж, цайны газар, компьютер, видео хурлын төхөөрөмж, хурд, согтуурал хэмжих багаж, хяналтын камер зэрэг тоног төхөөрөмжүүдийг нийлүүлсэн. Тухайлбал:

- Цагдаагийн ерөнхий газраас Цагааннуур тосгоны Улаанбайшинтийн боомтын чиглэлийн авто замын дагуу замын хөдөлгөөний хяналтын байнгын постыг барьж байгуулахад шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэсний дагуу постын барилгын гүйцэтгэлийн ажлыг “Сагсай өргөө” ХХК гүйцэтгэн 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ашиглалтанд хүлээлгэж өгөв.

Замын хөдөлгөөний байнгын пост баригдсанаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдах, орон нутгийн замд үйлдэгдэх зам тээврийн осол, хэрэг буурахад ач холбогдолтой болох нь хяналт шалгалтын ажил сайжирснаар харагдаж байна.

Тухайлбал: Тус замд 2017 онд үйлдэгдсэн 47 зөрчил илрүүлж байсан бол энэ онд 132 зөрчил илрүүлсэн.

- Жижүүр, харуулаар томилогдон 24 цагийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарт болон баривчлагдсан, саатуулагдсан иргэдэд эрүүл илчлэгтэй, халуун хоол хүнсээр хангах зорилгоор дотоод нөөц бололцоогоо ашиглан шинээр цагдаагийн газрын хашаанд гал зуух, цайны газрыг барьж, 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр ашиглалтанд оруулан ашиглаж байна.

- Цагдаагийн газрын төсвөөс хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, дотоодын цэргийн харуулын байр болон замын хөдөлгөөний хяналтын постын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 80 орчим тоон нүүрсийг олгосон.

- Цагдаагийн газрын дундын сангийн журмын дагуу нийт 73 алба хаагчдад 6.715.000 төгрөгний мөнгөн хэлбэрийн тусламж, дэмжлэг үзүүлэв.

- Алба хаагчдыг мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор үнэ төлбөргүй нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд хамруулдаг ажлыг аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран зохион байгуулж хэвшсэн бөгөөд “Эрүүл цагдаа хөтөлбөр”-ийн хүрээнд давхардсан тоогоор 463 алба хаагч, 71 ахмад ажилтныг хамруулсан.

Тав: Нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар уламжлан шийдвэрлүүлсэн ажил, арга хэмжээ, төсөв хөрөнгө, зарцуулалт, үр дүнгийн талаар:

1.1. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангуулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн хохирогчийг хамгаалах зорилгоор “Түр хамгаалах байр” барихад шаардагдах санхүүжилтийг аймгийн ИТХ-аас шийдвэрлэсний дагуу “Түр хамгаалах байр”-ыг ЗХ-ний 340 дүгээр анги барьж, 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ашиглалтанд хүлээлгэн өгсөн.

Мөн Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сангийн хамтран хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хүрээнд тус байрны тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил зэрэг нийт 70 орчим сая төгрөгний хөрөнгө оруулалт хийлээ.

1.2. Орон нутгийн хөрөнгөөр туулах чадвар сайтай тээврийн хэрэгслийг 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдөр нийлүүлснээр цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээний шуурхай байдал тодорхой хэмжээгээр хангагдлаа.

1.3. Орон нутгийн хөрөнгөөр 19.5 км авто замын эсрэг урсгалыг тусгаарлах цагаан шугам, 41 газарт явган хүний гарцын тэмдэглэл, 70 ширхэг босоо тэмдэг, аймгийн төвийн авто зам дагуу байрлалтай Ерөнхий боловсролын 6 сургуулийн ойр орчимд “Сургуулийн бүс” тэмдэг байрлуулах, Ховд-Өлгий-Цагааннуур чиглэлийн авто замд шинээр 210 ширхэг тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах ажлыг холбогдох төрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлээд байна.

Дээрх ажил, арга хэмжээний үр дүнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон бусад, хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хангагдаж жолооч болон иргэдийн зүгээс замын хөдөлгөөнд хууль, дүрмийн дагуу оролцох нөхцөл боломж нь бүрдсэн.

1.4. Аймгийн 12 сум, 1 тосгоны орон нутгийн хөрөнгөөс олон нийтийн цагдаагийн урамшил, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, бензин шатах тослох материал болон бичиг хэргийн зардал, кобаны галчийн ажлын хөлс, урсгал засвар, түлш, энгэрийн камер, сумын төвийг камержуулах зэрэг ажил, арга хэмжээнд нийт 60 орчим сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал:

Ногооннуур, Улаанхус сумын удирдлагууд кобаны өргөтгөл, авто граж хийх, гудамж, талбайд байрлуулах хяналтын камер түүний дагалдах хэрэгсэл, согтуурал хэмжих багаж, хэвлэх машин, энгэрийн камер зэрэг эд зүйлийг худалдан авахад шаардагдах 40 орчим сая төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэн дэмжлэг үзүүлсэн байна.

Зургаа: Тайлангийн хугацаанд хэрэгжүүлсэн шинэлэг санал, санаачлага:

1.1. “Google earth” программд “Гэмт хэргийн мэдээллийн сан” үүсгэж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ашиглаж байна.

1.2. Цагдаагийн газрын ажил, үйлчилгээг иргэд олон нийтэд түргэн шуурхай хүргэх, шийдвэрлүүлэхээр гаргасан асуудлыг богино хугацаанд эрх бүхий албан тушаалтанд танилцуулан шийдвэрлүүлэх зорилгоор үйлчилгээ авсан иргэдэд “Үйлчилгээний хуудас” тарааж, хууль зүйн зөвлөгөө өгсөн.

Мөн иргэдийг хүлээж авах танхимд угтах үйлчилгээ үзүүлэх алба хаагчийг өдөр бүр томилон ажиллуулж, үйлчлүүлсэн иргэдэд “Түр нэвтрэх хуудас” олгон үйлчилгээ үзүүлж байна.

1.3. Тус Цагдаагийн газрын соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор “Саян” телевизтэй хамтран 36 минутын “Сэтгэлийн үг” нэвтрүүлгийг бүтээж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээн сурталчлав.

1.4. Нийтийн хэв журам хамгаалах тасгийн Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчдаас санаачлан “Сайн үйлсийн аян” арга хэмжээний хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн эх, нярайн 2 өрөөг засварлах ажлыг 2018 оны 03 дугаар сарын 20-25-ны өдрүүдэд хийж гүйцэтгэн Нэгдсэн эмнэлгийн удирдлагуудад хүлээлгэж өгсөн.

Цагдаагийн газраас санаачлан зохион байгуулсан Е.Айсултан хүүгийн эмчилгээний зардалд туслах зорилгоор сэтгэлийн хандивын аяныг зохион байгуулсан

Тус Цагдаагийн газрын эмэгтэйчүүдийн зөвлөлөөс санаачлан нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх, эмзэг бүлгийг дэмжих зорилгоор Өлгий сумын 2, 5, 10 дугаар багт оршин суух өрх толгойлсон, амьдралын баталгаажих түвшинээс доогуур орлоготой 5 эмэгтэйд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын дэмжлэгтэйгээр хоол, хүнс, хувцас бусад эд зүйлийн туслалцаа үзүүлж, сэтгэлийн өглөг өргөсөн.

Долоо: Бусад ажлын талаар:

1.1. “Монгол цэргийн өдөр”, “Зэвсэгт хүчний 97 жилийн ойн баярыг тохиолдуулан тус аймаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулагдсан “Марш тактикийн цогцолбор” тэмцээнд цагдаагийн газрын алба хаагчид эр зориг, тэсвэр, хатуужил, авхаалж самбаагаа сорин амжилттай оролцон 2 дугаар байр, уламжлал болгон зохион байгуулагддаг “Аварга шалгаруулах-2018” тэмцээнд багийн дүнгээр цагдаагийн газрын баг, тамирчид 1-р байранд тус тус шалгарч, “Өргөмжлөл”, шилжин явах цомоор шагнууллаа.

1.2. ЦЕГ-ын “Хүч” спортын хорооноос 2018 оны 11 дүгээр сард зохион байгуулсан “Боксын аварга шалгаруулах” тэмцээнд тус Цагдаагийн газрын эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Х.Бекнур амжилттай оролцож Дэд байр, 2018 оны 12 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулагдсан насанд хүрэгчдийн улсын аварга шалгуулах боксын тэмцээнд ЦЕГ-ыг төлөөлөн оролцож, - 91 кг жинд 2-р байранд тус тус шалгарсан амжилт гаргав.

1.3. Улаанбаатар хотод 2018 оны 02 дугаар сарын 23-26-нд зохион байгуулагдсан “Монголын Үндэсний спортын VI их наадам”-ын “Мөсөн сурын харваа”-ны төрөлд цагдаа-жолооч, цагдаагийн дэд ахлагч, спортын мастер Б.Энхтүвшин тэргүүн байр эзэлсэн.

Мөн цагдаагийн ахлах дэслэгч Г.Наранзул “Мөсөн сурын спортын мастер”-ын болзлыг хангасан амжилт үзүүллээ.

1.4. Бүгд найрамдах Казахстан улсын “Qazagstan” телевизээс зохион байгуулсан “Би Казак хүн” олон улсын урлагийн их наадамд Монгол банкны гэрээт цагдаа, цагдаагийн дэд ахлагч Х.Игилик Монгол улсыг төлөөлж амжилттай оролцов.

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР